



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 0363

Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.5.1 дэх заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын "Хөдөлмөрийн дотод журам"-ын 3.11.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтны ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Иргэний нисэхийн ерөнхий газрын ёс зүйн дүрмийг сурталчлах, мөрдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Ёс зүйн хороо /Б.Мөнхбат/, Захиргаа, удирдлагын газар /Т.Батжаргал/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын "Ёс зүйн дүрэм батлах тухай" 2009 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 564 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН